ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАРТАЙ ХОЛБОГДОЛТОЙ ЗААЛТУУДЫН БИЕЛЭЛТ

2020.06.02

| ЗГҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр | Зарцуулах хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | 2020 оны хүрэх түвшин | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ОНЦГОЙ БОДЛОГО | | | | | | | | |
| Тэргүүлэх зорилт №2.1. Макро тэнцвэрийг бататгасан олон тулгуурт дотоодын үйлдвэрлэлд түшиглэсэн, тогтвортой эдийн засгийг бий болгон Монгол Улсын үндэсний нийт орлогыг нэмэгдүүлж, дундаж-дээгүүр орлоготой орнуудын эгнээнд буцаан оруулна. | | | | | | | | |
| 2.23. Иргэдийн эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж, хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын тогтолцоог бий болгож, хүнсний аюулгүй байдлыг сайжруулна. | 1 | Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх суурь судалгаа хийх, журам боловсруулах, сургалт зохион байгуулах | I-IV улирал | - | - | - Суурь судалгаа тооцооллыг гаргах аргачлалын талаар ХААТасгийн мэргэжилтнүүдэд мэдлэг олгох<br>- Жишсэн дундаж хүн амын тоог тооцож гаргах,<br>- Жишсэн дундаж хүн амын жилийн хүнсний хэрэгцээг тооцоолох | Сумдын мэргэжилтнүүдэд Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх суурь судалгаа хийх, Жишсэн дундаж хүн амыг тооцох, Жишсэн дундаж хүн амын жилийн хүнсний хэрэгцээг тооцох аргачлалын талаар цахимаар болон утсаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.<br>Мөн 2019 оны жилийн эцсийн хүн амын тоонд үндэслэн жишсэн дундаж хүн амыг тооцож гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний жилийн хүнсний хэрэгцээг аймаг сумдаар тооцооллыг хийсэн. Дэлхий нийтээр COVID-19 вирус тархаж УОК-оос Онцгой нөхцөл байдал зарласантай холбогдуулан 2020 оны 2 дугаар сараас эхлэн 7 хоног тутам хүнсний нөөцийн мэдээг сумдаар нэгтгэн ХХААХҮЯамны Хүнсний үйлдвэрийн хөгжлийн бодлого зохицуулалтын газарт өгч ажиллаж байна. | 100 |
| 2.25. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг сайжруулах, | 2 | “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын эхний үе шатны | I-IV улирал | - | - | “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хоёр дахь үе шатны үйл ажиллагааны болон “Төрөөс хүнс, хөдөө аж | Монгол мал хөтөлбөрийн 30 заалт, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого хөтөлбөрийн 32 заалт бүхий төлөвлөгөөг тус тус батлуулан 40 хувьтай хэрэгжүүлж | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| дэвшилтэт техник, технологийн шинэчлэлийг хийх, инновацийг нэвтрүүлэх, түүнчлэн “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ. | | төлөвлөгөө, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хоёр дахь үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, хэрэгжүүлэх | | | | ахуйн талаар баримтлах бодлого”-ын төлөвлөгөөний хэрэгжилтийг 80 хувьд хүргэх | байна. | |
| | 3 | Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл болон малын тэжээл, хадлан бэлтгэлд техник, технологийн шинэчлэл, инновацийг нэвтрүүлэх, лизингийн үйлчилгээг хөгжүүлэх | I-IV улирал | - | - | МАА-н үйлдвэрлэлийн техникийн шинэчлэлийг 20-иос доошгүй хувиар, дэвшилтэт технологи, инновацийн бүтээгдэхүүн нэвтрүүлэлтийг 15 хувиар нэмэгдүүлэх | Засгийн Газрын 2003 оны 6 дугаар 24-ны өдрийн 160 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар эрчимжсэн мал аж ахуй эрхлэх аймаг, сумдын жагсаалт батлагдсан ба тухайн жагсаалтад манай аймаг багтаагүй.<br>2020 онд Зах зээл бэлчээрийн эрсдлийн удирдлага төсөл бүх сумдад хэрэгжиж эхэлсэн ба Өвс тэжээлийн агуулах саравч-2, Бог мал угаах ванн 15, Инженерийн хийцтэй худаг-27 шинээр барих, Мал үржүүлэг технологийн багаж, тоног төхөөрөмж олгох, ажлын байрны засварт нийт 1,227.9 сая төгрөгийн шийдвэрлэж тендэр зарлаад байна.<br>НҮБ-ын Аж үйлдвэрийн байгууллагын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд “ Хонь хяргах төсөл”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Сайнцагаан суманд цахилгаан хайчаар хонь хяргах, мал эмнэлэгийн үйлчилгээ үзүүлэх сургалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Энэ төслийг Далай багийн малчин өрхүүдийг хамруулан зохион байгуулна. | 100 |
| 2.26. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол малчин”, “Малжуулах” хөтөлбөрийг | 4 | “Монгол малчин” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах | I-IV улирал | - | - | “Монгол малчин” хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах | Аймгийн “Монгол малчин” хөтөлбөрийн 2020 оны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж эхний хагас жилийн байдлаар 45 хувьтай байна. | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| хэрэгжүүлнэ. | 5 | “Малжуулах” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх | I-IV улирал | - | - | 1500 мал худалдан авахад дэмжлэг үзүүлэх | Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн тушаалаар 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 01 тоот тушаалаар 5,0 хүртэлх сая төгрөгний төслийн зээлийг 15 сумын 34 өрхөд 170,0 сая төгрөгний квотыг олгосон. | 40 |
| 2.30. Малыг бүртгэлжүүлж, малын гаралтай түүхий эд бэлтгэлийн чанар стандартыг дээшлүүлж, гарал үүслийг тодорхой болгох системийг бүрдүүлнэ. | 6 | Малын гаралтай түүхий эдийн стандартуудыг шинэчлэх, мөрдүүлэх, түүхий эдийн чанарыг орон нутагт хянан баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлэх, тоног төхөөрөмжийн дэмжлэгийг сумдад үзүүлэх | III-IV улирал | - | - | Малын ноос, ноолуур, сүүний чанарыг суманд хянан баталгаажуулах чадавхийг баруун бүсийн сумдад бий болгох | Аймгийн мал эмнэлгийн лабораторид 7.8 тн махны 2.0 тн сүүний нийт 89 сорьцын 9.8 тн мал амьтны гаралтай бүтээгдэхүүнд МЭАЦ-ийн магадлан шинжилгээг хийсэн. Итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод заасан шинжилгээний арга зүй, стандартын дагуу шинжилгээг хийж гүйцэтгэсэн.   2019 оны байдлаар 15 сумын 4278 өрхийн 281.9тн адуу мах, 641.0 тн тэмээний мах, 204.0 тн үхрийн мах, 830.5тн хонины мах, 312.0 тн ямааны мах, 1.6 тн гахай мах нийт 2271.0 тн мах, 2253 адууны шир, 284 үхрийн шир, 1591 тэмээний шир, 10054 хонины арьс, 29221 ямааны арьс, 140 л сүү, 915л хоормог, 815.5 тн ноос, 24.7 тн ноолуурт үзлэг хийж сумдын байцаагч мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээг баталгаажуулан олгоод байна. Малын эрүүл мэндийн нэгдсэн системд Мал эмнэлгийн | МЭГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гэрчилгээг 12 сараас эхлэн оруулж , 568 ширхэг мал эмнэлгийн гэрчилгээг олгон ажиллаж байна. | |
| 2.34. Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулах үйл ажиллагаанд зээлийн дэмжлэг үзүүлж, өвс тэжээлийн аюулгүй нөөцийг нэмэгдүүлнэ. | 7 | Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүсэд тэжээлийн үйлдвэр байгуулах, малын таримал тэжээлийн үр үржүүлгийн үйл ажиллагааг дэмжих | III-IV улирал | - | - | Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчилсэн байдлаар нэгийг шинээр байгуулах, тэжээлийн ургамлын үрийн шинэчлэл хийж тариалалтыг нэмэгдүүлэх | Хан дээж ХХК 2019 онд ЖДҮХСангаас 175,0 сая төгрөгний хөнгөлөлттэй зээл авч, “Тэжээлт бор” малын тэжээл, “Шимт бор” бордоо, “Хурдан бор” хурдан морины бэлдмэл нийт 3 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. 2020 оны 1 сараас эхлэн 4тн бүтээгдэхүүн борлуулж 32,0 сая төгрөгний борлуулалтын орлоготой ажилласан байна. 10 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байна. | 70 |
| | 8 | Өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх техник, тоног төхөөрөмжийг сайжруулж, өвс, тэжээлийн агуулахыг орон нутагт бий болгох | IV улирал | - | - | Өвс, тэжээлийн нөөцийн агуулахгүй сумдын байршлыг харгалзан шинээр 2 агуулах барьж, 1 агуулах сэргээн засварлах | Зах зээл бэлчээрийн эрсдлийн удирдлага төслийн 207.1, Орон нутгийн 88.7 сая төгрөгийн хөрөнгөөр Эрдэнэдалай, Баянжаргалан сумдад өвс тэжээлийн агуулах шинээр, Дэлгэрцогт суманд өвс тэжээлийн агуулахын засварын ажил хийгдэхээр гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийг зардлаад байна. | 40 |
| 2.35. Хөдөөгийн хүн ам болон мал аж ахуйн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор бэлчээрт худаг, хөв цөөрөм барьж байгуулан ашиглалт, хяналтыг сайжруулна. | 9 | Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор инженерийн хийцтэй болон энгийн уурхайн худаг гаргах, цас, борооны ус тогтоох хөв цөөрөм барьж байгуулах | III-IV улирал | - | - | Шинээр 30-аас доошгүй худаг гаргаж, хөв, цөөрөм барьж байгуулснаар нийт мал сүргийн усан хангамж 1,2 орчим хувиар нэмэгдэх | Улсын төсвийн 500,0 сая төгрөгөөр 20, Зах зээл бэлчээрийн эрсдлийн удирдлага төслийн 434,7, Орон нутгийн 186,3 сая төгрөгөөр 27 худаг, Азийн хөгжлийн банкны төслийн 120,0 сая төгрөгөөр 5 худаг буюу нийт 1,241,0 сая төгрөгийн хөрөнгөөр 52 худгийг шинээр гаргахаар батлагдаж гүйцэтгэгч шалгаруулах тендерийг зарлаад байна. Нийт 78 мян/га бэлчээрийг усжуулж, усан хангамж 1,2 орчим хувиар нэмэгдэнэ. | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 10 | Нар, салхины сэргээгдэх эрчим хүчийг ашиглан газрын гүнээс ус татах тоног төхөөрөмжийг хуучин инженерийн хийцтэй худгуудыг засварлан суурилуулах, худаг гаргах үйл ажиллагаанд шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх | I-IV улирал | - | - | Инженерийн хийцтэй 25-аас доошгүй худагт нар, салхины эрчим хүчээр ажиллах ус өргүүр суурилуулах | Хугацаа болоогүй | 0 |
| 2.39. Эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг тогтоон үр тариа, төмс, гол нэрийн хүнсний ногоог 100 хувь, таримал тэжээлийн 50 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангана. | 11 | Газар тариалангийн механикжсан ажлыг төлбөртэй гүйцэтгэж өгдөг аж ахуйн нэгж, хоршоонд техник, технологийн шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх, төмс хүнсний ногоо үйлдвэрлэлийн техникийн шинэчлэл хийх | I-IV улирал | Хувийн хэвшил | 20.0 | Төмсний үйлдвэрлэлд 12 хувь, хүнсний ногооны үйлдвэрлэлд 3 хувьд хүргэх | Хаврын тариалалтын явцын мэдээгээр төмс -9,7 га, хүнсний ногоо 8 га талбайд тариалаад байна.<br>Аймгийн хэмжээний тариалалтын явц 51 хувьтай байна. | 40 |
| 2.40. Жимс жимсгэний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, чацарганы үйлдвэрлэлийн нэгдсэн сүлжээ байгуулан, хүн амыг амин дэм бүхий жимс жимсгэнээр хանган, экспортын орлогыг нэмэгдүүлнэ. | 12 | "Жимс жимсгэнэ" хөтөлбөр хэрэгжүүлж, Монголд ургах боломжтой жимс жимсгэний сортуудыг турших, нутагшуулах, үржүүлэх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх, | II-IV улирал | Хувийн хэвшил | 13,2 | Жимс жимсгэний тариалалтыг 5 га-д хүргэх | 2019 онд 74,2 га талбайд жимс жимсгэний мод тариалж ургалтын хувь 80 хувьтай байна.<br>Эхний 5 сарын байдлаар ХХААХҮЯамнаас ирүүлсэн “Жимсний суулгац зээлээр олгох” төслөөс 1 иргэн 100ш чацарганы суулгац авч 0,1 га-д тариалалт хийсэн байна. | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | чацарганы тариалалт, хураалт, хадгалалт, боловсруулалт, борлуулалтын чанар стандарт, судалгаа шинжилгээнд суурилсан сүлжээг үүсгэж, өрсөлдөх чадварыг сайжруулан "Монгол чацаргана" бренд бий болгох, экспортод тогтвортой гаргах | | | | | | |
| 2.43. Усны хайгуул, судалгаанд үндэслэн услалтын систем шинээр барьж, сэргээн засварлах, усалгааны дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхийг дэмжиж, усалгаатай | 13 | Хайгуул судалгаа хийгдсэн бүсүүд болон томоохон голуудын сав газарт урсацын тохируулга хийж, ус хуримтлуулах усан сан бүхий томоохон услалтын системийн толгойн барилга, усыг талбайд хүргэх гол суваг (хоолой), талбай хоорондын ус хуваарилах сүлжээний барилга байгууламжийг барих | I-IV улирал | -. | - | Усалгаатай тариалангийн эргэлтэнд 3.5 мян.га талбайг шинээр ашиглалтад оруулах, 8.2 мян.га талбайн усан хангамж сайжрах | ХАМААРАЛГҮЙ ЗААЛТ. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.44. Өвөл, зуны хүлэмжийн загвар, цогцолбор аж ахуйг хөгжүүлж, хот суурингийн хүн амыг шинэ ургацын ногоогоор тогтвортой хангана. | 14 | Өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулахад урт хугацаатай зээлийн эх үүсвэр бий болгох, томоохон хот суурин газруудад гадаад орон, олон улсын байгууллагын санхүүжилтээр загвар, цогцолбор аж ахуйнуудыг байгуулах, зуны хүлэмжийн аж ахуйн хангамжийг сайжруулж, орон нутагт хөнгөлөлттэй үнэ, нөхцөлөөр нэвтрүүлэх | II-III улирал д | Төсөл хөтөлб өр | 20,0 | Хүлэмжийн талбайг 1000м$^2$-аар, ургацын хэмжээг 20 тн-оор нэмэгдүүлэх. | 2020 онд Сайнцагаан суманд 480 м2 хүлэмжинд тариалалт хийгдэж, Говь-Угтаал суманд 720 м2 талбай бүхий 6 хүлэмжийг ОНХСангийн хөрөнгөөр байгуулахаар гүйцэтггэгч сонгон шалгаруулах тендер зарлагдаж хүлэмжийн талбайг өмнөх оноос 1200м2-аар нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүллээ. | 100 |
| 2.48. Үйлдвэржилтийн 21:100 хөтөлбөрийг хэрэгжүүлж, импортыг орлох экспортын чиглэлийн тэргүүлэх болон жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ. | 15 | “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийг боловсруулан батлуулах | I-IV улирал | - | - | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувиар | “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөөг батлуулан хэрэгжилт 50 хувьтай хэрэгжиж байна. | 40 |
| | 16 | Ахуй үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх | I-IV улирал | - | - | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувиар | Ахуй үйлчилгээний салбарыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн төсөл боловсруулагдаж байгаа ба 6 дугаар сард багтаан батлуулахаар төлөвлөгөөнд тусгасан. | 40 |
| | 17 | "Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 21 аймагт 100 нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад | II-IV улирал | - | - | Биелэлт хангагдаж, хөнгөн болон хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай | “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийн хүрээнд Талх нарийн боов, Мах, махан бүтээгдэхүүн Ингэний сүүн бүтээгдэхүүн, Тэмээний ноосон бүтээгдэхүүн боловсруулах 4 үйлдвэр байгуулахаар төлөвлөсөн.<br>Уг ажлын хүрээнд 2019 онд ЖДҮХСангаас иргэн О.Энхбат ”Талх нарийн боовны үйлдвэрлэлээ | 40 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | санхүү, эрх зүйн дэмжлэг үзүүлж ажиллах | | | | орчин бүрдэж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ 5 хувьд хүрэх. | өргөтгөх”-өөр 90,0 сая төгрөгийн зээл авч үйлдвэрийн барилгын барих ажил 70 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр Ноён шанхай ХХК судалгааны ажил хийгдэж дууссан. Орон нутгийн зүгээс үйлдвэрлэл байгуулах газрын асуудлыг шийдвэрлэж дэмжлэг үзүүллээ.<br>Тэмээний ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгч Ш.Бөндөгхорол нь үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөө шинэчлэн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэхээр төслөө ирүүлснийг дэмжин СХСангаас 15,0 сая төгрөийг олгоод байна.<br>Ингэний сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулахаар “Шилийн хурд” ХХК нь ЖДҮХСанд төслөө ирүүлээд байна. | |
| 2.51. Ноос, ноолуур, арьс ширэн түүхий эдийн бэлтгэл тээвэрлэлт, үндэсний үйлдвэрт тогтвортой нийлүүлэх тогтолцоог бүрдүүлж, түүхий эдийн санг бий болгоно. | 18 | Түүхий эдийн бэлтгэл, тээвэрлэлтийг боловсронгуй болгож, үндэсний үйлдвэрт тогтвортой нийлүүлэх тогтолцоог бүрдүүлэх | III-IV улирал | | | Орон нутгаас тээвэрлэх ноосны тээврийн зардлыг 10 хувиар, арьс ширэн түүхий эдийн нядалгааны үеийн механик гэмтлийг 30 хүртэл хувиар бууруулж, анхан шатны тордолтыг стандартын дагуу хийн, чанарыг хамгаалах боломж бүрдэх, арьс ширний үнэ цэнэ нэмэгдэж, хаягдал буурах | Засгийн газрын 2019 оны 343 дугаар тогтоолын дагуу үндэсний боловсруулах үйлдвэрт хонь, тэмээний ноос бэлтгэж тушаасан малчин, мал бүхий 1811 иргэнд 700289 кг ноосонд 1’018’491’200’00 ₮-ийн мөнгөн урамшуулал, мөн Засгийн газрын 2013 оны 394 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий 1999 иргэнд хонь 133826ш, ямаа 133295ш, үхэр 1780ш, адуу 284ш, нийт 269185ш арьс ширэнд 776’034’000 төгрөгийн мөнгөн урамшуулал олгогдоод байна. Монгол улсын Засгийн газрын 2020 оны 165-р тогтоолын дагуу А дансандаа ямаа тоолуулсан малчдад ноолуурын урамшуулал 8592 малчинд 1’849’284 ямаанд 11’095’704’000 төгрөгийн | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | урамшуулал олгогдож эхлээд байна. 2020 оны ЖДҮХСангийн хөнгөлөлттэй зээлд арьс шир түүхий эдийн анхан шатны боловсруулалт тордолт хийх, чиглэлээр 6 аж ахуйн нэгжийн 570,0 сая төгрөгний төслийн хүсэлт ирээд байна. . | |
| Дундаж 100-4,70-2 40-9, хугацаа болоогүй-1 | | | | | | | | |